



**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2009 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 577 / 486

Улаанбаатар хот

Байнгын комисс байгуулах тухай


Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай 2007 оны 7 сарын 3-ны өдөр байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, эрүүл мэндийн чиглэлээр бакалаврын болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын тогтолцоог эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлоготой уялдуулах зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хамтарсан дүгнэлт, санал гаргах Байнгын комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Дор дурьдсан чиглэлээр асуудал шийдвэрлэхэд Байнгын комиссын дүгнэлт, саналыг үндэслэж байсугай. Үүнд:

- 2.1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн болон бакалавр, магистр, докторын түвшний сургалт эрхлэх байгууллага байгуулах болон шинэ мэргэжил нээх;
- 2.2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагын элсэлтийн хяналтын тоо тогтоох;
- 2.3. Эрүүл мэндийн шинжлэх ухааны чиглэлээр эзэмшүүлэх мэргэжлийн чиглэл, индекс тогтоох, шинэчлэх;
- 2.4. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургалтын байгууллагуудыг аттестатчилах;
- 2.5. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаатай холбоотой бусад асуудал.


3. Байнгын комиссын үйл ажиллагааны жил тутам танилцуулж байхыг Комиссын дарга (Б.Мишигжав)-д даалгасугай.



ЭРҮҮЛ МЭНДИЙН

САЙД


С.ЛАМБАА



БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ

САЙД

Б.ОТГОНБАЯР



Эрүүл мэнд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны
сайдын 2009 оны 7 сарын 13 өдрийн 37/148 тоот
хамтарсан тушаалын хавсралт

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, Эрүүл мэндийн яамны дэргэдэх
байнгын комиссын бүрэлдэхүүн**

- | | |
|----------------------------------|---|
| Комиссын дарга | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны
Төрийн нарийн бичгийн дарга |
| Комиссын дэд дарга | Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн
дарга |
| Комиссын нарийн бичгийн
дарга | Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын дарга |
| Гишүүд | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны
Мэргэжлийн боловсролын газрын дарга |
| | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны
Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга |
| | Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын орлогч дарга |
| | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны
Мэргэжлийн боловсролын газрын Дээд
боловсролын агуулга, үнэлгээ стандарт,
магадлан итгэмжлэлийн бодлого зохицуулалт
хариуцсан мэргэжилтэн |
| | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны
Санхүү, хөрөнгө оруулалтын газрын
Боловсролын төлөвлөлт, төсвийн нэгтгэл
хариуцсан мэргэжилтэн |
| | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны
Мэргэжлийн боловсролын газрын дээд
боловсролын сургалтын байгууллагын тусгай
зөвшөөрөл, аттестатчилал, улсын бүртгэлийн
асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны
Мэргэжлийн боловсролын газрын Мэргэжлийн
боловсролын сургалтын байгууллагын тусгай
зөвшөөрөл, аттестатчилал, улсын бүртгэлийн
асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | БШСУЯ-ны Төрийн захиргааны удирдлагын
газрын Боловсролын болон худалдан авах |

ажиллагааны эрх зүйн зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын Салбарын удирдах ажилтны
болон дээд мэргэжилтний нөөцийн бодлого,
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын Эрүүл мэндийн болон
эмнэлгийн дунд мэргэжилтний нөөцийн бодлого,
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны ТЗУГ-ын Хууль эрх зүйн
үйлчилгээ, зөвлөгөө, өргөдөл гомдлын
шийдвэрлэлтийн хяналт, тайлагналт хариуцсан
мэргэжилтэн

- - - ооо - - -